БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2011 оны 06 сарын 03 өдөр Дугаар А/06 Олгосон

Дотоод үйл ажиллагааны журам батлах тухай

Газрын харилцаа геодези, зураг зүйн газрын /хуучин нэрээр/ даргын 2008 оны 83 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Иргэн хуулийн этгээдэд газар эзэмших, ашиглах, эзэмшлийн газрын хэмжээнд өөрчлөлт оруулах, шилжүүлэх, гэрчилгээг сунгах ажлуудыг иргэдэд түргэн шуурхай, үйлчилж, олон дахин ирүүлэхгүйгээр уг журмыг мөрдөж ажиллахыг сумдын газрын даамлуудад даалгасугай.

2. Уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын удирдлагын хэлтсийн дарга /Ж.Естай/-д үүрэг болгосугай.

ДАРГА К.БОЛАТ

БАТЛАВ
Аймгийн Газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын газрын
дарга К.БОЛАТ

ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТИЙГ ХҮЛЭЭН АВАХ, ТҮРГЭН ШУУРХАЙ ШИЙДВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

1. Зорилго

1.1. Газрын тухай хуулийн 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр, газрын албаны эрх хэмжээнд "газар эзэмших, ашиглах эрхийг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлд бүртгүүлж, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд улсын бүртгэлийн дугаарыг тэмдэглэх" эрх нэмэгдсэн. Энэ шат, дамжилгыг хөнгөвчилж иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ хүргэхэд зорилго нь оршино.

2. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. Иргэн, хуулийн этгээд газрын алба, газрын даамалд:

- шинээр газар эзэмших, ашиглах;
- газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх;
- газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгах;
- талбайн хэмжээ өөрчлөх тухай хүсэлтэй гаргахдаа ГХГЗЗГ-ын /хуучин нэрээр/ даргын 2008 оны 83 дугаар тушаалаар баталсан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмыг мөрдөх.

2.1.1. Шинээр газар эзэмших, ашиглах, эзэмшил газрын хэмжээнд өөрчлөлт оруулах, газар эзэмших эрхийн гэрчилгээг хэсэгчлэн хуваах газрын хэмжээнд өөрчлөлт оруулан шилжүүлэх, улсын бүртгэлийн дугаар аваагүй газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгах тохиолдол бүрт улсын бүртгэлд явуулах мэдүүлгийг хамт бөглүүлж, мэдүүлгийн он, сар, өдрийг бөглөхгүй орхиж захирамж гарсаны дараа улсын бүртгэлд илгээхдээ нөхөж бөглөнө.

2.2. Иргэн, хуулийн этгээд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний үнэ, кадастр хэвлэх үнэт цаасны үнэ, нэгж талбарын хувийн хэргийн үнийг төлсөн баримт болон газрын төлбөр төлсөн баримтыг өргөдөл өгөхдөө хавсаргаж өгөх.

2.3. Иргэн, хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, хүсэлтийг сумын газрын даамал, кадастрын мэргэжилтэн нар бүрдүүлэх материалын бүрэн эсэхийг шалгаж тэр даруй кадастрын мэдээллийн санд бүртгэж өргөдөл хүлээн авсан тухай тодорхойлолтыг өргөдөл гаргагчид хэвлэж олгоно.

2.4. Өргөдөл хүлээн авах, хянаж шийдвэрлэх бүх үйл явцыг ГХГЗЗГ-ын /хуучин нэрээр/ даргын 2008 оны 83 дугаар тушаалаар баталсан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

2.5. Захирамжийн төслийг долоо хоног бүрийн 3 өдрийн өглөө аймаг, сумын Засаг даргад уламжлана.

2.6. Долоо хоног бүрийн 5 дахь өдрийн үдээс хойш Засаг даргын захирамжийг бүртгэх, иргэн, хуулийн эдгээдийн өргөдлийг улсын бүртгэлд илгээх, нэгж талбарын хувийн хэргийг үүсгэх ажил хийгдэх тул иргэдэд үйлчилгээ үзүүлэхгүй дотоод ажил байна.

----------oOo----------